

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

2025 оны 08 дугаар сарын 15-ны өдөр

“НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР”-ЫН 2024-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.САРАНЦЭЦЭГ

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
ХОЁР.МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ	4-8
ГУРАВ. АЛСЫН ХАРАА	9
ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО	9
ТАВ. ҮНЭТ ЗҮЙЛС	9
ЗУРГАА. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ (SWOT), (PESTLE)	10-12
ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ	13
НАЙМ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	14-20
ЕС. БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ	21-22
АРАВ.ХАВСРАЛТ	23-24

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1.МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ
 ХҮСНЭГТ 2.ЧИГ ҮҮРЭГ, ЭРХ ХЭМЖЭЭ
 ХҮСНЭГТ 3.ХОЛБОГДОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦОО
 ХҮСНЭГТ 4.ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1.НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
 ХОЛБОГДОГЧ ТАЛУУД
 ЗУРАГ 2.НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН БҮТЦИЙН СХЕМ
 ЗУРАГ 3.НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН СТРАТЕГИЙН ЗОРИЛГО
 БА БҮТЦИЙН УЯЛДАА

Нэг.Нийтлэг үндэслэл:

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтууд, Нийслэлийн хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн нийгэм, эдийн засгийн зорилтуудыг хэрэгжүүлэх, нийслэлийн нутаг дэвсгэрт биеийн тамир, спортыг хөгжүүлэх таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, иргэдэд чанартай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг - Нийслэлийн Биеийн тамир, спортын газар юм.

Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.” гэж заасан болно. Мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216, 2023 оны 301, 2025 оны 43 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар өгөгдсөн заавар, журмын дагуу нийслэлийн хэмжээнд биеийн тамир, спортын талаарх хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулав.

Энэхүү стратегийг боловсруулахад Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2025-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдэд биеийн тамир, спортын чиглэлээр тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөв.

Хоёр.Мандатын шинжилгээ

Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Төрийн байгууллагын чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар өгөгдсөн зааврын дагуу Нийслэлийн Биеийн тамир, спортын газар мандатын шинжилгээг хийлээ.

Мандат нь төрийн байгууллагын хуульд заасан чиг үүрэг болон эрх хэмжээтэй салшгүй холбоотой ойлголт юм.

Мандатын шинжилгээгээр тус байгууллагын эрхлэх асуудал нь нийт 18 хуулийг хамарч байна. Үүнээс байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд шууд хамаарах 1 хуулийн хүрээнд чиг үүргийг нарийвчлан тодорхойллоо

Хүснэгт 1.Мандатын шинжилгээ

Салбарын үйл ажиллагаанд мөрдөж байгаа нийт хууль	18 хууль	
Үүнээс	Тухайн салбарын хууль	1
	Нийтлэг хууль	17
Ерөнхий чиг үүрэг: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангах		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
1.Нийслэлийн иргэдэд эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, зөв дадлыг хэвшүүлж, эрүүл мэндээ хамгаалах, хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох.	1.1.Нийслэлийн иргэдийн дунд биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулж, оролцоог нэмэгдүүлэх;	Биеийн тамир, спортын Улсын хороо; Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Биеийн тамир, спортын хороод; Нийслэлийн нутгийн захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллага; Спортын холбоод, клуб.
	1.2.Нийслэлийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, дүүрэг, хороо, хэсгүүдийн биеийн тамир, спортын клубын үйл ажиллагааг эрчимжүүлэх арга зүйн зөвлөгөө өгөх;	
	1.3.Нийслэлийн хэмжээнд хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорил авах ажлыг зохион байгуулан үнэлж дүгнэн мэдээллийн сан бүрдүүлэх;	
	1.4.Нийслэлийн иргэдэд идэвхтэй хөдөлгөөний чиглэлээр стандартад нийцсэн үйлчилгээ үзүүлэх;	
2.Спортын төрлүүдийг хөгжүүлэх, өсвөр үе,	2.1.Өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчид, ахмад,	Нийслэл Засаг даргын Тамгын газар,

залуучуудын ур чадварыг дээшлүүлэх.	хөгжлийн бэрхшээлтэй тамирчдын дунд спортын төрлүүдийг хөгжүүлэх;	Дүүргийн Биеийн тамир, спортын хороод, Спортын холбоод, Төрийн бус байгууллагууд
	2.2.Багийн спортоор дамжуулан хүүхэд залуучуудын авьяас, ур чадварыг хөгжүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	
	2.3.Биеийн тамир, спортын төрийн болон төрийн бус байгууллагуудад дэмжлэг үзүүлж хамтарч ажиллах;	
	2.4.Дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн бүтэц, тогтолцоог боловсронгуй болгох дасгалжуулагч тамирчдын амжилтыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;	Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Биеийн тамир, спортын хороод, Спортын холбоод
	2.5.Биеийн тамир, спортын чиглэлээр гадаад харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх.	Гадаадын ижил төстэй байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулах
3.Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулсан спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх	3.1.Нийслэл дэх Биеийн тамир, спортын барилга байгууламж заал, талбай, техник, тоног төхөөрөмжийн төлөвлөлт, ашиглалтын стандартад хяналт тавих ажлыг зохион байгуулах;	Биеийн тамир, спортын Улсын хороо, Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Дүүргийн Биеийн тамир, спортын хороод
	3.2.Нийслэлд биеийн тамир, спортын барилга байгууламжийг төлөвлөх, барих асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;	
	3.3.Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлнэ.	Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим санд мэдээлэл байршуулах Дүүргийн Биеийн тамир, спортын хороод

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын чиг үүргийг холбогдох хууль, тогтоомжид тулгуурлан тодорхойлсон бөгөөд тухайн чиг үүргийг захиргааны эрх хэмжээний ангиллаар авч үзсэн. Энэ хүрээнд Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ыг суурь болгон үзвэл дараах байдлаар гарч байна.

1.Бодлого боловсруулах - Нийслэлийн салбар, орон нутгийн урт, дунд, богино хугацааны стратеги зорилт боловсруулах, төлөвлөх, хууль тогтоомжийн төсөл, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, стандарт тогтоох, бодлогын хэрэгжилтийн үнэлгээ хийх чиглэлээр Засгийн газар, яамд болон нутгийн удирдлагын байгууллагуудын эрх хэмжээ хамаарна.

2.Зохицуулалт хийх – Тодорхой үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр төрийн байгууллагаас зөвшөөрөл, лиценз, магадлан итгэмжлэх, гэрчилгээ олгох зэрэг эрх хэмжээ хамаарна.

3.Зохион байгуулах – Тухайн шатны төрийн байгууллагад хуулиар тогтоож өгсөн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг удирдан чиглүүлэх эрх хэмжээ хамаарна.

4.Санхүүжилт – Төрийн байгууллага, нутгийн удирдлагын байгууллагуудын чиг үүргээ хэрэгжүүлэхэд

5.Хүний нөөцийн бодлого – Удирдах албан тушаалтан болон албан хаагчдыг томилох, чөлөөлөх, чадавхжуулах, бэлтгэх, давтан сургах, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх зэрэг эрх хэмжээ хамаарна.

6.Хяналт, үнэлгээ хийх – Төрийн байгууллагын дэвшүүлсэн зорилт, түүний хэрэгжилт, хүрсэн үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэх, ажлын чанар, гүйцэтгэлд хяналт шалгалт болон дотоод аудит хийх эрх хэмжээ хамаарна.

7.Үйлчилгээ үзүүлэх – Төрөөс үзүүлэх үйлчилгээг төрийн байгууллага болон нутгийн удирдлагын байгууллага, эсхүл гэрээний үндсэн дээр хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх эрх хэмжээ хамаарна.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын чиг үүргийг авч үзвэл дараах байдалтай байна. Хүснэгт 2-т үзүүлэв.

Хүснэгт 2 Чиг үүрэг, эрх хэмжээ

№	Чиг үүрэг	Захиргааны хэм хэмжээ						
	Чиг үүрэг	Бодлого боловсруулах	Зохицуулалт хийх	Зохион байгуулах	Санхүүжилт	Хүний нөөцийн бодлого	Хяналт, үнэлгээ хийх	Үйлчилгээ үзүүлэх
1.	Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангах			✓	✓	✓	✓	✓
1.1.	Нийслэлийн иргэдэд эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, зөв дадлыг хэвшүүлж, эрүүл мэндээ хамгаалах, хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох.			✓	✓	✓	✓	✓
1.2.	Спортын төрлүүдийг хөгжүүлэх, өсвөр үе, залуучуудын ур чадварыг дээшлүүлэх.			✓	✓	✓	✓	✓
1.3.	Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулсан спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх			✓	✓	✓	✓	✓

Газрын үйл ажиллагаанд холбогдогч талууд:
Холбогдох талуудыг тодорхойлохдоо Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын бусад байгууллагатай харилцах эрх хэмжээг үндэслэв.

Зураг 1. Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагаанд холбогдогч талууд



Эдгээр холбогдогч талуудын оролцоог мэдээлэх, зөвлөх, санал өгөх, хамтран ажиллах, шийдвэр гаргах гэсэн ерөнхий ангиллын хүрээнд тодорхойлсон болно.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхдээ эдгээр холбогдогч талуудтай харилцах бөгөөд холбогдогч талууд өөрт хамаарах эрх хэмжээний хүрээнд тодорхой үүрэг оролцоотойгоор хамтран ажиллана.

Хүснэгт 3. Холбогдогч талуудын оролцоо

№	Холбогдогч талууд	Оролцоо					
		Мэдээлэх тайлагнах	Зөвлөх, эргэх холбоогоор хангах	Санал өгөх	Хамтран ажиллах	Шийдвэр гаргах	Хяналт тавих
1.	Нийслэлийн Засаг дарга		✓	✓	✓	✓	✓
2.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар		✓	✓	✓	✓	✓
3.	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал		✓		✓	✓	
4.	УИХ		✓		✓	✓	
5.	Засгийн газар		✓		✓	✓	
6.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар		✓		✓	✓	

7.	Яамд		✓		✓	✓	
8.	Засгийн газрын агентлаг		✓		✓	✓	
9.	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба		✓		✓	✓	
10.	Нийслэлийн Засаг даргын дэргэдэх агентлаг, харьяа байгууллага	✓	✓	✓	✓		
11.	Дүүргийн Засаг даргын Тамгын газар	✓	✓	✓	✓		
12.	Дүүргийн Биеийн тамир, спортын хороод	✓	✓	✓	✓		
13.	Хороод	✓	✓	✓	✓		
14.	Хэвлэл мэдээллийн байгууллага	✓	✓		✓		
15.	Олон улсын байгууллага	✓	✓	✓	✓		
16.	Сургалт, судалгааны байгууллага	✓	✓	✓	✓	✓	
17.	Иргэд	✓	✓	✓	✓		
18.	ААНБ	✓	✓	✓	✓		
19.	Спортын холбоод (Төрийн бус байгууллага)	✓	✓	✓	✓	✓	
20.	Ажилтнууд	✓		✓	✓		
21.	Гадны нийлүүлэгчид	✓		✓	✓		
22.	ЕБС, СӨББ	✓		✓	✓		

Чиг үүргийн хэрэгжилтийн талаарх үнэлгээг гаргахдаа Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын ажилтнууд болон холбогдох талуудын дунд явуулсан санал асуулгын үр дүнд тулгуурласан.

Хүснэгт 4. Чиг үүргийн хэрэгжилт

№	Чиг үүрэг	Оролцогч талуудын үнэлгээ (хувь)	Албан хаагчдын үнэлгээ (хувь)	Дундаж хувь
1.	Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангах	65,4	96,3	80,8
1.1.	Нийслэлийн иргэдэд эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, зөв дадлыг хэвшүүлж, эрүүл мэндээ хамгаалах, хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох.	66	96,3	81
1.2.	Спортын төрлүүдийг хөгжүүлэх, өсвөр үе, залуучуудын ур чадварыг дээшлүүлэх.	66	96,3	81
1.3.	Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулсан спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх	64,4	96,3	81

Гурав. Алсын хараа

Эрүүл, идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэнийг төлөвшүүлж, өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг бэлтгэх ээлтэй орчныг бүрдүүлж, биеийн тамир, спортын салбарын манлайлагч байгууллага болно.

Дөрөв. Эрхэм зорилго

Нийслэлийн иргэдэд биеийн тамир, спортын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэж, эрүүл зөв амьдралын дадлыг бий болгож, тамирчдын амжилтыг ахиулна.

Тав. Үнэт зүйлс

Хууль ёсыг дагах. Монгол Улсын хууль тогтоомжийг чандлан сахиж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

Инновацилаг байх. Шинэ санаа, оновчтой шийдлийг эрэлхийлэх.

Шударга, хариуцлагатай. Үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ шударга байх зарчмыг баримталж, хариуцсан ажилдаа хариуцлагатай хандах.

Чадварлаг баг. Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд ур чадвар, орчин үеийн шийдэл, мэдээллийн технологийг эзэмшиж, үр бүтээлтэй багаар ажиллах.

Зургаа. Орчны шинжилгээ (SWOT)

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын өмнө тулгамдсан асуудал, цаашид хүрэхээр зорьж байгаа зорилго, зорилт, түүнийг хэрэгжүүлэх стратегийг тодорхойлохын тулд SWOT шинжилгээг дотоод болон гадаад хүчин зүйлийн хүрээнд хийлээ. Стратегийг боловсруулахын тулд хуулийн хүрээнд тодорхойлогдсон чиг үүргээ хэрэгжүүлэх чадавхын өнөөгийн давуу, сул тал, орчны нөлөөллийн боломж, эрсдэлийг илэрхийлэх гол хүчин зүйлсийг тус тус сонгож авсан болно.

Стратегийн зорилтыг тодорхойлохдоо тус шинжилгээний үр дүнд тулгуурлан давуу талдаа түшиглэн, сул талаа бууруулахад чиглэсэн арга замыг сонгож, гадаад орчны боломжийг ашиглаж, эрсдлийг бууруулах зарчмыг баримталсан.

Хүснэгт 5. Орчны шинжилгээ (SWOT)

ДОТООД ОРЧИН	
Давуу тал 1. Улс, Нийслэлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй сайн уялдуулдаг. 2. Хамт олны уур амьсгал сайн нийтэч, багаар ажилладаг. 3. Нийслэлийн төсвөөс Биеийн тамир, спортын үйл ажиллагааны санхүүжилт нэмэгдсэн. 4. Спортын холбоод, төрийн бус байгууллагуудтай нээлттэй хамтран ажилладаг. 5. Өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг бэлтгэх тогтолцоог бүрдүүлж ажилладаг.	Сул тал 1. Орон тоо хүрэлцээгүй байгаа нь ажил, үүргийн давхардал бий болгож, ажлын ачааллыг нэмэгдүүлж байна. 2. Салбарын хүний нөөцийг мэргэшүүлэх, мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх бодлого сул. 3. Иргэдэд биеийн тамир, спортын ажил үйлчилгээ үзүүлэх Нийслэлийн Биеийн тамир, спортын цогцолбор байхгүй. 4. Улсын төсвөөс хуваариладдаг санхүүжилт маш бага тул хүрэлцээ хангалтгүй. 5. Биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэхэд орчин үеийн мэдээллийн

	технологийн программ, системийг нэвтрүүлэх шаардлагатай.
ГАДААД ОРЧИН	
Боломж 1.Нийслэлд олон улсын болон дотоодын томоохон уралдаан тэмцээн зохион байгуулах боломжтой. 2.Туршлага солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжтой. 3.Олон улсын жишигт нийцсэн барилга байгууламж, талбайг байгуулах.	Эрсдэл 1.Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбар нэгдсэн яамтай болсон боловч спортын салбарт төрөөс тавих бодлого зохицуулалт хангалтгүй. 2.Үйл ажиллагааны төсөв, санхүүжилтийн хуваарилалт бага. 3.Олон улсын жишигт нийцсэн спортын барилга, байгууламж хангалтгүй. 4.Нийслэлийн эвент томоохон ажлуудын нэр, логог бусад байгууллага хуулбарлах. 5.Илүү цагаар ажиллах, орон тоо дутуу байгаа албан тушаалыг хавсран гүйцэтгэж нэг хүн 2-3 албан тушаалын ажил хариуцан гүйцэтгэж байгаа нь ажлаас гарах эрсдэл өндөр.

SWOT шинжилгээ нь байгууллагын дотоод давуу болон сул тал, гадаад орчны боломж ба аюул заналыг илрүүлэн тодорхойлох стратегийн чухал хэрэгсэл юм.

Энэхүү шинжилгээний зорилго нь байгууллагын өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ өгч, цаашдын хөгжлийн стратегийг оновчтой төлөвлөхөд оршино. SWOT шинжилгээ хийснээр байгууллага дотоод нөөц боломжоо бүрэн ашиглах, тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэх, мөн гадна орчны эерэг боломжийг ашиглан сөрөг нөлөөллөөс сэргийлэх суурь мэдээллийг олж авдаг.

Иймд SWOT шинжилгээ нь стратеги төлөвлөгөө боловсруулах үйл явцын голлох хүчин зүйл болдог бөгөөд байгууллагын удирдлагад шийдвэр гаргахдаа баримтлах бодит үндэслэл, нотолгоог бүрдүүлдэг.

Гадаад орчны хувьд SWOT шинжилгээг баяжуулан PESTLE шинжилгээ давхар хийх замаар тодорхойллоо. Улаанбаатар хотын биеийн тамир, спортын салбарт нөлөөлж буй гадаад хүчин зүйлсийг улс төр, эдийн засаг, нийгэм соёл, техник, технологи, хууль эрх зүй, байгаль орчны зүгээс үзүүлэх нөлөөллийг тодорхойлон, ямар эерэг боломж, ямар сөрөг нөлөөлөл, эрсдэл байгааг гаргав.

Хүснэгт 6.Гадаад орчны шинжилгээ (Pestle)

Нөлөөлөгч хүчин зүйлс	Эерэг асуудлууд	Сөрөг асуудлууд
Засгийн газрын бодлогын өөрчлөлт	Бүтэц орон тоог нэмэгдүүлсэн /шинэчилсэн/	- Хэвтээ тогтолцооноос босоо тогтолцоонд шилжсэн өөрчлөлттэй холбоотой хууль болон эрх зүйн зохицуулалтаас шалтгаалж бүтэц орон тоо, цалин хангамж, үйл ажиллагааны санхүүжилтийн асуудал сайжрахгүй орхигдох - Спортын салбарын бодлого тогтвортой бус, байнга өөрчлөгдөж, хэрэгжилт удаан байх - Бүтэц, орон тоо, санхүүжилт босоо тогтолцоотой байгаа боловч зохион байгуулалт хэвтээ (Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг) байгаа нь үйл

		ажиллагаа хэвийн тогтвортой явж чадахгүй байдалд хүргэх
Төрийн бодлогын дэмжлэг	Биеийн тамир спортын үйлчилгээг хүргэх орчин нөхцөл сайжирч байгаа	Хангалттай төсөв баталж өгдөггүйгээс спортын төрлүүдийг бүрэн гүйцэд хөгжүүлэх, иргэдэд хүртээмжтэй үйлчилгээг хүргэж чаддаггүй.
	Засаг даргын дэмжлэг сайн	- Босоо тогтолцоотойгоос аливаа арга хэмжээний зардал цаг тулгаж эсвэл хоцорч ирэх - Зохион байгуулалтын арга хэмжээний зорилго, ач холбогдлыг бүрэн ойлгодоггүйгээс төсөвлөсөн зардал байнга хасагддаг.
Санхүүжилт тусламж, хөрөнгө оруулалт	Зарим дүүргүүдэд спорт цогцолборын барилга байгууламж нэмэгдэж байгаа	- Хөрөнгө оруулалтын төсвийг богино хугацаанд бүрэн гүйцэд шийдвэрлэж өгдөггүй нь үндсэн өртөг, зардал нэмэгддэг үндсэн шалтгаан болох - Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь спортын барилга байгууламжгүй байгаа нь шаардлагатай үйл ажиллагаагаа зохион байгуулахад зардал гаргах нөхцөл болж байгаа
Инфляци		Инфляциас хамаарч төлөвлөсөн тэмцээн, уралдаан, арга хэмжээний батлагдсан төсөв хүрэлцэхгүй байдалд хүргэх, зохион байгуулж байгаа арга хэмжээний хүртээмж буурах шалтгаан болох
Хүн амын өсөлт	Биеийн тамир спортоор тогтмол хичээллэгчид нэмэгдэж байгаа	- Боловсон хүчний хүрэлцээ муу, зарим спортын барилга байгууламж стандартын дагуу хийгддэггүй. - Биеийн тамир, спортын барилга байгууламжийн хүртээмж, орчин нөхцөл хангалтгүй.
Боловсролын түвшин		Ажлын орчин, нөхцөл, цалин хангамж хангалтгүй байгаа нь чадварлаг боловсон хүчин бүрдүүлэх боломжгүй болгож байгаа
Мэргэжил		Төрийн албаны шалгалтын шалгуурыг хангасан боловсон хүчин бэлтгэгдэж чадахгүй байна.
Техник технологийн дэвшил		- Байгууллагын цахим хуудасны хөгжүүлэлт муу - Техник технологийн дэвшилтэд хүрч ажиллаж чадамж сул. - Биеийн тамир, спортын зарим үйлчилгээг цахимд шилжүүлэх ажил удааширалтай.

Биеийн тамир спортын тухай хууль	Оюутны шигшээ баг байгуулах болон хороодод биеийн тамир, спортын орон тооны арга зүйч ажиллах асуудал “Биеийн тамир, спортын тухай хууль”-д тусгагдсан.	○ Хуульд тусгах шаардлагатай саналаа илэрхийлсэн ч зарим асуудал тусгагдаагүй. ○ Тамирчдын залгамж халаа, нөөцийг бэлтгэхэд чиглэсэн өсвөрийн шигшээ багийг санхүүжүүлэх тухай заалт байхгүй зөвхөн дэмжих гэсэн заалт байгаа нь улсаас төсөв хөрөнгө шийдэх эрх зүйн орчин бүрэн гүйцэд шийдэгдээгүй нөхцөл болж байна.
Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль		○ “Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.“нэгж” гэж аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороог; 11 дүгээр зүйлийн 11.1. дэх заалт “Хороо нь иргэдэд хуульд заасан үйлчилгээ хүргэх, нутгийн өөрийн удирдлагад иргэдийн оролцоог хангах чиг үүрэг бүхий анхан шатны нэгж мөн.” гэж заасан боловч хороодод биеийн тамир, спортын орон тооны арга зүйч ажиллах асуудал бүрэн шийдэгдээгүй.
Цаг уур		○ Биеийн тамир, спортын уралдаан, тэмцээн зохион байгуулахаар бодлогын баримт бичигт тусгасан ажлуудыг зохион байгуулахад бороо, цас, салхи зэрэг цаг агаарын үзэгдэл нь оролцогчид болон зохион байгуулагчдад нөлөөлж хойшлох, эсвэл зохион байгуулах боломжгүй нөхцөл үүсдэг.

Долоо.Стратегийн зорилго:

Биеийн тамир, спортын бодлого, хөгжлийн хэтийн чиглэлийг тодорхойлж, хууль, эрх зүй, хүний нөөцийг мэргэшүүлэх тогтолцоог сайжруулж, хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг нэмэгдүүлж, өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэх замаар тамирчдын амжилтыг ахиулж, орчин нөхцлийг сайжруулан хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Стратегийн хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ.

1.Нийслэлийн иргэдийг биеийн тамир, спортын дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэхэд чиглэсэн үйлчилгээг сайжруулна.

2.Үндэсний болон орчин үеийн спортын төрлүүдийг хөгжүүлнэ.

3.Өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг бэлтгэнэ.

4.Нийслэлийн хэмжээнд биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

5.Тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОД ТҮВШИН

Зорилт	Арга зам	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2024 он)	Зорилтот түвшин (2025-2028 он)	Санхүүгийн эх үүсвэр
Үндсэн чиг үүрэг: Нэг.Нийслэлийн иргэдэд эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, зөв дадлыг хэвшүүлж, эрүүл мэндээ хамгаалах, хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох.					
1.Нийслэлийн иргэдийг биеийн тамир, спортын дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэхэд чиглэсэн үйлчилгээг сайжруулна.	Арга хэмжээ – 1.1. Нийслэлийн хэмжээнд хүн амын бие бялдар, хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллана.	А, В, С үнэлгээтэй иргэдийн эзлэх хувь	76%	79%	Нийслэлийн төсөв
	Арга хэмжээ - 1.2. Нийслэл хэмжээнд нийтийг хамарсан биеийн тамирын (Улаанбаатар марафон гүйлт, Иргэдийн спортын наадам, бүжгийн наадам, нийтийн гимнастикийн наадам, “Улаанбаатар цом” усанд сэлэлтийн наадам, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн наадам, “Алхацгаая гүйцгээе хөдөлгөөн” гэх мэт) эвент арга хэмжээг зохион байгуулна.	Оролцогчдын тоог жил бүр 5 хувиар нэмэгдүүлнэ.	888,500	1079976	Улс, нийслэлийн төсөв
	Арга хэмжээ – 1.3. Өвлийн спортын арга хэмжээг зохион байгуулж иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	Оролцогчдын тоог жил бүр 5 хувиар нэмэгдүүлнэ.	425,100	518273	Нийслэлийн төсөв
	Арга хэмжээ – 1.4. Идэвхтэй хөдөлгөөнд суурилсан явган аялал, алхалт, гүйлт, иог, фитнессээр хичээллэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажлыг хийж мэдлэг боловсролыг дээшлүүлнэ.	Цахим орчинд хандалт авсан хүний тоо	1,895,450	3636047	Нийслэлийн төсөв

	Арга хэмжээ – 1.5. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, дүүрэг, хороо, хэсгүүдэд биеийн тамирын хамтлаг байгуулах ажлыг эрчимжүүлж, үйл ажиллагааг жигд хүртээмжтэй болгоно.	Хамтлагийн тоо	820	840	-
	Арга хэмжээ – 1.6. Биеийн тамир, спортын хороод, спорт клуб, ерөнхий боловсролын сургуулийн секц, дугуйланд биеийн тамир, спортоор тогтмол хичээллэгчдийн тоог нэмэгдүүлнэ.	Тогтмол хичээллэгчдийн эзлэх хувь	30%	38%	Улс, нийслэлийн төсөв
	Арга хэмжээ – 1.7. Биеийн тамир, спортын зарим ажил, үйлчилгээг цахимд шилжүүлнэ.	Цахим үйлчилгээний тоо	8	14	Улс, нийслэлийн төсөв
Үндсэн чиг үүрэг: Хоёр. Спортын төрлүүдийг хөгжүүлэх, өсвөр үе, залуучуудын ур чадварыг дээшлүүлэх.					
2. Үндэсний болон орчин үеийн спортын төрлүүдийг хөгжүүлнэ.	Арга хэмжээ – 2.1. Нийслэл, дүүргийн хэмжээнд үндэсний болон орчин үеийн спортын төрлөөр уралдаан тэмцээн зохион байгуулна.	Оролцогчдын тоог жил бүр 5 хувиар нэмэгдүүлнэ.	273,000	331,832	Улс, Нийслэлийн төсөв
	Арга хэмжээ – 2.2. Нийслэлд олон улсын тэмцээнүүдийг зохион байгуулах, оролцох, харилцан туршилга судлах ажлыг зохион байгуулна.	Гадаад арга хэмжээний тоо	9	12	Улс, Нийслэлийн төсөв
3. Өндөр зэрэгтэй тамирчдын халааг бэлтгэнэ.	Арга хэмжээ – 3.1. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх оюутны шигшээ багийг байгуулж, бэлтгэл сургалт хийх, дотоод, гадаадын тэмцээн, уралдаанд оролцох, амжилт гаргах нөхцөлийг хангана.	Оюутны шигшээ багийн төрлийн тоо	0	12	Нийслэлийн төсөв
	Арга хэмжээ – 3.2. Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн бүтэц бүрэлдэхүүнийг шинэчилэх,	шигшээ багийн төрлийн тоо	30	35	Дүүргийн төсөв


	өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг бэлтгэнэ.				
	Арга хэмжээ – 3.3. Биеийн тамир, спортын үндсэн үйл ажиллагаанд зориулсан сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн, эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулна.	Оролцогчдын тоо	2600	2700	Улсын төсөв
	Арга хэмжээ - 3.4. Нэр хүндтэй тамирчин, дасгалжуулагчдаар ёс зүй, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	20	30	-
Үндсэн чиг үүрэг: Гурав.Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулсан спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх					
4.Нийслэлийн хмэжээнд биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Арга хэмжээ - 4.1. Дүүргүүдэд баригдаж байгаа спорт цогцолборуудыг ашиглалтад оруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	Ашиглалтад орсон спортын барилгын тоо	4	3	Улс, Нийслэл, дүүргийн төсөв
	Арга хэмжээ – 4.2. Нийслэлийн гэр хороолол, дэд төв, дагуул хотуудад норм стандартын дагуу спортын барилга байгууламжийг барьж байгуулан хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Спортын барилга байгууламжаас 20 минутын зайд амьдарч буй хүн амын эзлэх хувь	Тооцох	T+5%	Улс, Нийслэлийн төсөв
	Арга хэмжээ – 4.3. Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран биеийн тамир, спортын зориулалтын талбайг барьж байгуулна.	Тохижуулсан талбайн тоо	203	283	Улс, Нийслэл, дүүргийн төсөв бусад
	Арга хэмжээ – 4.4. Хүн амын бие бялдрын чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын төв байгуулна.	Төвийн тоо	2	6	Улсын төсөв

	Арга хэмжээ – 4.5. Биеийн тамир, спортын салбарын стандартад санал өгөх, сурталчлах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	Ажлын тоо, хүртээмж	4 ажил, 1230 хүн	6 ажил, 6000 хүн	-
5.Тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлнэ.					
5.1.Зорилго, алсын хараа, стратегийг сайжруулна.	Арга хэмжээ - 5.1.1. Зохион байгуулалтын нэгжээс албан хаагч нар болон шинээр орсон ажилтнуудад байгууллагын алсын хараа, стратегийн талаар чиглүүлэх сургалт, хэлэлцүүлгийг хагас, бүтэн жилээр зохион байгуулж байна.	Албан хаагчдын стратегийн ойлголт, мэдлэгийн өөрчлөлт (хувь)	80	90	Улсын төсөв
5.2.Байгууллагын соёл ба манлайллыг хөгжүүлнэ.	Арга хэмжээ - 5.2.1. Байгууллагын дүрэм, шаардлагатай журмуудыг шинэчлэн батлуулж хяналт тавьж ажиллана.	Өгсөн зөвлөмжийн дагуу сайжруулсан ажлын өөрчлөлтийн хувь	-	≥80	Улсын төсөв
	Арга хэмжээ - 5.2.2. Шинэ санаачилга, манлайллыг дэмжих урамшууллын тогтолцоог бий болгож хэрэгжүүлнэ.	Байгууллагын ажилтан, албан хаагчдын манлайллын өөрчлөлт (хувь)	-	T+15%	Улсын төсөв
5.3.Оролцогч талуудын оролцоог хангана.	Арга хэмжээ - 5.3.1. Төр, хувийн хэвшил, ивээн тэтгэгч, спортын салбарын байгууллагыг хамарсан оролцогч талуудын зөвлөл байгуулж, бодлого шийдвэрт оролцуулах.	Хэлэлцсэн саналын 60%-ийг шийдвэр гаргалтад тусгана.	-	≥60	-
	Арга хэмжээ - 5.3.2. Биеийн тамир, спортын үйлчилгээ, хүртээмжийн талаар олон нийтийн судалгааг зохион байгуулж, сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.	Судалгааны үр дүн (өөрчлөлтийн хувь)	65	75	-


5.4.Тогтвортой үнэ цэнийг бий болгоно.	Арга хэмжээ - 5.3.3. Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах төвүүдийг бий болгож иргэдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.	Сорилд хамрагдсан иргэдээс цахим төвөөр үйлчлүүлсэн иргэдийн хувь	10	50	Улсын төсөв
	Арга хэмжээ - 5.4.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын чиг үүргийн хүрээний мэдээллийг олон нийтэд ил тод хүргэнэ.	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний өөрчлөлт (хувь)	52,4	≥70	-
	Арга хэмжээ - 5.4.2. Биеийн тамир, спортын үйл ажиллагаанд ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цахим шилжилтийг эрчимжүүлж салбарын онцлогт нийцсэн шинэ технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн шийдвэр гаргалтад хиймэл оюун ухаан их өгөгдлийг ашиглана.	Байгууллагын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнээс цахимд шилжүүлсэн үйлчилгээний эзлэх хувь	5	≥10	Улс, нийслэлийн төсөв
	Арга хэмжээ - 5.4.3. Олон улс, тив, дэлхий, спорт наадмууд зохион байгуулж буй гадаадын орнуудад ажилтан, албан хаагч нарыг оролцуулж туршлага солилцох хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Албан хаагчдын чадамжийн өөрчлөлт (хувь)	70	≥80	Улсын төсөв
5.5.Гүйцэтгэл ба өөрчлөлтийн удирдлагыг сайжруулна.	Арга хэмжээ – 5.5.1. Дүүргүүдийн хороодод орон тооны биеийн тамир, спортын арга зүйчтэй болох асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэж, иргэдийг өдөр тутмын биеийн тамир, спортын дасгал хөдөлгөөнөөр хичээллэх тэгш хүртээмжтэй үйлчилгээг нэмэгдүүлнэ.	Биеийн тамир, спортоор тогтмол хичээллэгчдийн өөрчлөлт (хувь)	30	38	Дүүргийн төсөв
	Арга хэмжээ - 5.5.2. Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO-9001:2016 стандартыг хэрэгжүүлнэ.	Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO-9001:2016	80	≥90	-

		стандартын хэрэгжилтийн үнэлгээ (өөрчлөлтийн хувь)			
	Арга хэмжээ - 5.5.3. Өөрчлөлтийн менежментийн хөтөлбөр боловсруулж, шинэчлэлийн үеийн ажилтнуудын дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэх.	Ажилтнуудын шинэчлэлд дасан зохицох чадварын үнэлгээ	-	T+15	-
5.6.Оролцогч талуудын сэтгэл ханамж, ойлголтыг сайжруулна.	Арга хэмжээ - 5.6.1. Салбарын байгууллага, ивээн тэтгэгч, иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг жил бүр явуулж, үр дүнг тооцож, үйл ажиллагааг сайжруулна.	Судалгааны үр дүнгийн өөрчлөлт (хувь)	75	85	Улсын төсөв
	Арга хэмжээ - 5.6.2. Иргэдийг биеийн тамир, спортын дасгал хөдөлгөөнөөр хичээллэж эрүүл амьдралын хэв маягийг бүрдүүлэхэд чиглэсэн PR ба дижитал контент хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Олон нийтийн танин мэдэх түвшин нэмэгдсэн өөрчлөлт (хувь)	50	70	Улс, нийслэл, бусад
	Арга хэмжээ - 5.6.3. Итгэлцэл, ил тод байдлыг дэмжих зорилгоор биеийн тамир, спортын нээлттэй уулзалт, хэлэлцүүлэг, тайлангийн арга хэмжээ зохион байгуулна.	Оролцогчдын мэдээлэл авсан өөрчлөлтийн хувь	-	T+10	Улсын төсөв
5.7.Стратегийн болон үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулна.	Арга хэмжээ - 5.7.1. Стратеги төлөвлөгөөний биелэлтэд жил тутамд хяналт шинжилгээ хийж, стратеги үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулна.	Стратегийн хэрэгжилт (өөрчлөлийн хувь)	-	≥90	-

Зураг-2. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын бүтцийн схем



Зураг-3. Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын стратегийн зорилго, зорилт ба бүтцийн уялдаа.



Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс стратегийн 1, 5, 6 дахь зорилтыг, Спорт, нийтийн биеийн тамирын хэлтэс стратегийн 2, 3, 4 дэх зорилтуудыг тус тус удирдан зохион байгуулж ажиллана.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын стратеги зорилгыг хэрэгжүүлэхэд зохион байгуулалтын нэгж тус бүр өөрсдийн чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна нэгж хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог хангаж ажиллана.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагааг
зохицуулсан эрх зүйн баримт бичгийн жагсаалт
Холбогдох хуулиуд

- 1.Монгол Улсын Үндсэн Үндсэн хууль
- 2.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль
- 3.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- 4.Биеийн тамир, спортын тухай хууль
- 5.Төсвийн тухай хууль
- 6.Төрийн албаны тухай хууль
- 7.Хөдөлмөрийн тухай хууль
- 8.Захиргааны ерөнхий хууль
- 9.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- 10.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль
- 11.Хууль тогтоомжийн тухай хууль
- 12.Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- 13.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль
- 14.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах
- 15.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль
- 16.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
- 17.Хүүхдийн эрхийн тухай хууль
- 18.Хүүхэд хамгааллын тухай хууль

Холбогдох тогтоол, захирамжууд

- 1.Засгийн газрын тогтоол №43 “Хяналт-шинжилгээ хийх журам”, Үнэлгээ хийх журам”. 2025.01.29
- 2.“Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам” 2021.12.30
- 3.Монгол Улсын хууль “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” 2023.05.04
- 4.Засгийн газрын тогтоол №216 “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”. 2020.12.16 7.
- 5.Засгийн газрын тогтоол №217 “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”.2020.12.16
- 6.ЗГХЭГ даргын тушаал №100 “Стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал, тайлангийн загварууд”. 2020.12.31 10. НИТХ-ын Тэргүүлэгчид №54
- 7.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол №65 “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”. 2022.02.22
- 8.Нийслэлийн Засаг даргын А/1049 дүгээр захирамж “Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай”. 2022.08.15